



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 04 дугаар сарын 15

№ 06/97 ГАГ-2018-01-ГА.

Манзановъ хот

Г

Зөрчил арилгуулах тухай

1

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Дундговь аймаг дахь Төрийн аудитын гадрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийж буй гүйцэтгэлийн аудитаар 139,105,812.00 /Нэг зуун гучин есөн сая нэг зуун таван мянга найман зуун арван хоёр/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ.

1. “Музейн барилгын засварын ажил”-ын магадлашгүй ажлын зардлас ажлын төсөвт багтсан ажлыг санхүүжүүлсэн, мөн тухайн байгууллагад ашиглагдах байсан хөрөнгийг шинээр худалдан авсан гэж 289,000.00 /Хоёр зуун наян есөн мянга/ төгрөгийн санхүүжилт олгосон.

Энэ нь Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Барилгын төсөв зохиох дээрэм”-ийн 8.2-т /Магадлашгүй ажлын энэ нөөц хөрөнгийг барилгын гүйцэтгэвч, захалагч байгууллагууд хариуцан тохиоролцсны үндсэн дээр зураг төсөлд тусгагдаагүй фисныг санхүүжүүлэхэд зарцуулна./ Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 415 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.12-д /Төсвийн магадлашгүй ажлын зардлыг зөвхөн захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хамтран тогтосон шакт, магадлашгүй ажлын тосов, гүйцэтгэлийг үндэслэн олгоно./ гэж заасныг тус тус зөрчсөн.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилгын 71,354,312.00 /Далан нэгэн сая гурван зуун тавин дөрвөн мянга гурван зуун авсан хоёр/ төгрөгийн их засварын ажил, 35,893,000 /Гучин таван сая найман зуун ерэн цувран мянга/ төгрөгийн буудлын их засварын ажлыг хувийн хэрэгт нэмж хөтлөөгүй.

Энэ нь Барилын тухай хуулийн 33.1.18-д /Барилга байгууламжийн хувийт хэрэг хотлох журмыг батлах/, 46.1.2. /Энэ хуулийн 33.1.18-д заасан журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэрэг хотлох/, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалаар батлагдсан барилга байгууламжийн хувийн хэрэг хотлох журмын 1.3-д /Барилга байгууламжийн хувийн хэрэг нь тухайн барилга байгууламжийн эдэлгээний хугацаанд хийгдсэн түргэлт, өөрчлөлт, шинэчлэл, их засварын ажил, узлагч шалгамт, гарсан эвдэрэл, гэхэдээл, согогын татаарх мэдээлэл, уг барилга байгууламжийн үндсэн узүүлэлтийг агуулсан барилт бичиг байна./ гэж заасныг тус тус зөрчсөн.

3. Номын сангийн барилгын 5,978,500.00 /Таван сая есөн зуун далан найман мянга таван зуу/ төгрөгийн засварын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэсэн.

Энэ нь Барилгын тухай хуулийн 40.2-т /Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно./, Төсвийн тухай хуулийн 29.4-т /Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөвөө батлуулсан, хувьд заасан бусад завшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгина./ гэж заасныг тус тус зөрчсөн.

4. “Цагаандэлгэр сумын Цэцэрлэгийн барилгын дээврийн засварын ажил”, “Музейн барилга, цэвэр бохирын шугам, халаалтын засвар, дохиолол хамгаалалтын систем засварын ажил”, “Аймгийн ЗДТГ-ын автомашини парк засвар”, “Орон нутгийн өмчийн байрны засвар”, “Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин”, “Цагдаагийн газрын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл” нийлүүлэх ажлуудын худалдан авах ажиллагааны захиалагч нь аймгийн Засаг дарга байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д /Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад дор дурдсан этгээд захиалагч байна/, 45.2.2-д /аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн орон нутгийт худалдан авах барийн, ажил, үйлчилгээний хувьд мөн 45.3-д /Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар захиалагч байна/, 46.1.3-т /үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах/ гэж заасныг тус тус зөрчсөн.

5. Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх 75,000,000.00 /Далан таван сая/ төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 50,000,000.00 /Тавин сая/ төгрөгийн төсөвт өртөгтэйгээр харьцуулалтын арга хэрэглэн зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д /Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангшил тус бүрээр дараахь босго үнийг тогтооно:/ 8.1.1-д /харьцуулалтын аргаар худалдан авч болох барийн, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар/, мөн 8.2-т /Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртгөтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хувьд өөрөөр заагшгүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэгжиц/, 8.4-т /Тендер шалгаруулалтын журмыг сонгоходоо тухайн бараа, ажил, үйлчилгээний ийт төсөвт өртгийг үндэслэх болгоно/. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн босго үнэ шинэчлэн батлах тухай 68 дугаар тогтоолын хавсралтыг тус тус зөрчсөн байна.

6. Цагаандэлгэр сумын Цэцэрлэгийн барилгын засварын ажлын 591,000.00 /Таван зуун ерэн нэгэн мянга/ төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй боловч магадлашгүй ажлын зардлаас санхүүжилт олгосон.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 415 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.12-д /Төсвийн магадлашгүй ажлын зардолыг зөвхөн захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хамтран тогтоосон акт, магадлашгүй ажлын төсөв, гүйцэтгэлийг үндэслэн олгоно./ заасныг зөрчсөн.

7. Худалдан авах ажиллагааны баримтын бүрдэл дутуу архивын нэгж үүсгэсэн /Хавсралт I/. Мөн “Хулд сумын дотуур байрны засвар”, “Цагаандэлгэр сумын Цэцэрлэгийн дээврийн засвар”, “Модел хаус”, “АЗДТГ-ын автомашины парк засвар”, “АЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин”, “АЗДТГ-ын тоног төхөөрөмж”, “АЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин” нийлүүлэх төсөл, арга хэмжээний тендерийн үнийн санал ирүүлэх талаар 3 болон түүнээс дээш этгээдэд мэдэгдсэн албан бичиг, баримт байхгүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д /Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хаваст хэрэг бүрдүүжис архивын нэгж болгон

хэдгэлна/, мөн 49.2-д /Төндөрийн хаваст хэрэг дараах баримт бичиг, материалыж бүрдэнэ/, 33.2-д /Харьцуулалтын аргыг дараах байдалаар хэрэгзэнэ/, 33.2.1-д /техникийн тодорхойлж болон бусад тохиуяа, шаардлагыг хангаж байгаа З болон түүнээс дээш эмзээдээд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх/ гэж заасныг тус тус зөрчсөн.

Терийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад шэрээн төлбөр, зорчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага огх хууль тогтоомж, эрх зүйн хэмжээс тогтоосон бусад ишлэвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны шийтийг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад шэрээн төлбөрийг барагдуулах, зорчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага огх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхэд баримтлах журмын 4.1.5-д /Байгуулсан гэрээ, хэлцэл мордож байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага, нохцлийг хангахүй/, 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зорчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гээс үзсэн бусад нохцэл байдаз/ гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. “Музейн барилгын засварын ажил”-ын төсөвт багтсан ажил болон хуучин тухайн байгууллагад ашиглагдаж байсан хөрөнгийг магадлашгүй ажлын зардлаас санхүүжүүлсэн 289,000.00 /Хоёр зуун нааш есен мянга/ төгрөгийг гүйцэтгэгч компаниар нохен төлүүлэх;
2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажил, буудлын их засварын ажлыг барилгын хувийн хэрэгт нэмж хөглөх;
3. Номын сангийн барилгын засварын ажлын гүйцэтгэлийн ажлын зургийг гүйцэтгэгч компаниас авч, архивт хадгалах;
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагаанд Засаг даргын Тамгын газар захиалгачаар ажиллах;
5. Төндер шалгаруулалтын журмыг сонгоходоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгож байх;
6. Цагаандэлгэр сумын Цэцэрлэгийн барилгын засварын ажлын гүйцэтгэгүй ажилд магадлашгүй ажлын зардлаас санхүүжүүлсэн 591,000.00 /Таван зуун ерэн нэгэн мянга/ төгрөгийг гүйцэтгэгч компаниар нохен төлүүлэх;
7. Худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр хуульд заасны дагуу төндер шалгаруулалтын хаваст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгалиж байх;
8. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор албан ёссоор ирүүлэхийг аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Эрдэнэ-Очир, Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаяр, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Э.Чагнаадорж нарт хариуцуулав.

# АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨРСӨН:

АХЛАХ  
АУДИТОР

Ч.БЭРХСАЙХАН  
ООД  
ТӨЛӨВЛӨЛТҮҮСЛҮҮЛГҮҮС

ЗӨВШӨӨРСӨН:

АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН  
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ЭРДЭНЭ-ОЧИР

ОРОН НУТГИЙН  
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА

С.УУГАНБАЯР

ГАЗРЫН ХАРИЛЦАА,  
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА

Э.ЧАГНААДОРЖ

1 Акты, албан шаардлагын биеэлээт хангаагдаажүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн өвтэг цаг хугацаанд нь биеэлүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрээт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.